



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар Б/91

Бор-өндөр сум

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1, 123.2, 123.2.1, Нэгдсэн эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн удирдлагын багийн хурлын шийдвэрээр Мэс заслын эмч М.Ганхуяг нь Нэгдсэн эмнэлгийн дотоод журмыг зөрчиж, үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай үзүүлэхэд доголдол гаргаж, ажил тасалсан тул сахилгын шийтгэл ногдуулсугай.
2. М.Ганхуягт ганцаарчилсан хэлбэрээр хаалттай сануулах арга хэмжээ авч, үр дүнгийн урамшууллыг 3 сараар хасаж тооцсугай.
3. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу өдөр тутмын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг баримтлан ажиллаж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг М.Ганхуягт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (Б.Энхмаа)-д даалгасугай.

ДАРГА  А.БАТБААТАР

1820060013
ХТҮЗ746 ТЕАГУТҮГ 9075615